



## ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.01.24

Дархан-Уул аймаг

### 1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

#### Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр:

- ✚ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022-01-11 -ны өдрийн 13 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн
- ✚ Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022-01-13 -ны өдөр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.
- ✚ 2022 оны эцэг, эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлууласан.
- ✚ ГНС -ын ГТ-9 маягт, ГТ-2 , ГТ-3 маягт / тайланг тус тус гарган ГЗБГЗЗГ-т холбогдох мэргэжилтэнд mail – ээр хүргүүлсэн.
- ✚ ГӨ-ийн болон ГЗБТ -ний хэрэгжилт, бичмэл тайланг хүргүүлэв.
- ✚ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 9 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн.
- ✚ Иргэн С.Эрдэнэбат нь эзэмшил газраа цуцлуулах хүсэлт өгсөн. Хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулсан.
- ✚ Цахим танхимд хуваарийн дагуу 2022-01-19 өдөр ажилласан. Нийт 12 өргөдөл илгээсэн

#### Мониторингийн чиглэлээр:

- ✚ Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан болон дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр Эхлэх цэг хангай ХХК-ийн гүйцэтгэсэн 1 тайлан дүгнэлтийг шалгаж мониторингийн цахим системээр баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✚ Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх өмчлөлийн 3, эзэмшлийн 4 иргэнд хянан баталгаа хийлгэх тухай мэдэгдэх хуудсыг хэвлэж өгсөн.
- ✚ 2021 оны Газрын нэгдмэл сангийн тайлангийн ГТ-1,5 ГНС-ийн балансын тайлбар, ГТ-1 холбогдох зурган файл, БОХ-1,1 тайлан, ГТ-6,7 болон зураг файл, БОХ-1.2, ГТ-4 тайланг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

#### Геодези, зураг зүйн чиглэлээр:



Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг шалгаж хүлээн авсан. Үүнд:

- Дархан сум. 11-р баг. 13-р хороолол. Үндэсний эрх чөлөө 3-315 Б блок улаан шугам
- Хаягийн зургийн дагуу 11 иргэн, 11 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- Шинэчлэн бүртгэлд хамрагдаагүй 2 иргэн 0 аж ахуй нэгж, газраа хувааж бусдад шилжүүлсэн 4 иргэний эзэмшил, өмчлөлийг газрыг ажлын нэгж талбарт шилжүүлсэн.
- Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 8 иргэн, 1 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.

### Газрын төлбөрийн талаар:

Газрын төлбөрийн тайлан мэдээг нэгтгэж гаргасан.

№	Сумын нэр	2021 оны орлогын Төлөвлөгөө /төг/	Нэхэмжлэл үүсгэсэн байдал /төг/	Гүйцэтгэлийн хувь	Газрын төлбөрийн орлого /төг/	Гүйцэтгэлийн хувь
1	Дархан	1,020,500,000	1,273,663,556	125	916,181,480	90
2	Орхон	33,500,000	23,770,659	71	28,937,017	86
3	Хонгор	361,000,000	397,326,437	110	308,587,079	85
4	Шарын гол	85,000,000	99,162,418	117	92,881,423	109
	<b>Аймгийн хэмжээнд</b>	<b>1,500,000,000</b>	<b>1,793,923,070</b>	<b>120</b>	<b>1,346,586,999</b>	<b>90</b>

- Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга"-ыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх, захиргааны хэм хэмжээний акт гаргуулах тухай танилцуулга материал бэлтгэж, 2022.01.12-ний өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж дэмжүүлсэн.

### Дархан сум:

- Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчилсөн газраа бусдад шилжүүлсэн худалдсан 8 бэлэглэсэн 2 иргэний кадастрын мэдээллийн сангийн өөрчлөлтийг хийж цахим системд бүртгэсэн. Мөн дархан суманд газар эзэмшиж, ашиглаж байгаа 7 иргэн, хуулийн этгээдийн кадастрын зургийг тус тус гаргаж өгсөн.
- Мэдээллийн санд бүртгэгдээгүй газар өмчилсөн 3 иргэний нөхөн бүрдүүлж цахимжуулсан.
- Шинээр газар өмчилсөн 8 иргэний өмчлөлийн захирамж, кадастрын зураг, хянан баталгааны дүгнэлтийн хуудасыг хэвлэн нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн баталгаажуулалтыг хийлээ.



- ✚ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралд танилцуулах 21 иргэний өргөдөл хүсэлттэй танилцан суурин судалгааг хийж хуралд танилцуулах танилцуулга бэлтгэж байна.
- ✚ Өмнөх хурлаар орж өмнө газар өмчилсөн 5 иргэнд хариу мэдэгдэх худсаар хариуг хүргүүллээ.

## **2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

### **Барилга материалын үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн хүрээнд:**

- ✚ Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 29 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019/12/18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 1 сарын 24-ны байдлаар 21 мэдээ ирсэн байна. Хугацаа болоогүй шалтгаанаар бусад ААНБ үйлдвэрлэлийн мэдээ ирүүлээгүй байна.

### **Барилгын хяналт шалгалтын хүрээнд:**

- ✚ Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1) болон ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-ирүүлсэн маягтын дагуу хүргүүлсэн.
- ✚ Дархан-Уул аймгийн хэмжээнд барилгын түр хашаа татсан, нүх ухсан, түр хашаа нь эвдэрсэн барилга байгууламжуудын судалгааг гаргаж ЗАА-д хүргүүлсэн.
- ✚ Дархан сум, 15-р багт баригдах 960 хүүхдийн сургуулийн барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх ажлын зөвшөөрлийг холбогдох заавар зөвлөгөөг өгч олгосон.

### **Хот байгуулалтын кадастр, зураг төслийн хүрээнд:**

- ✓ Дархан арьс шир боловсруулах цогцолбор байршлын зураг
- ✓ Дархан арьс шир боловсруулах цогцолбор зургийн даалгавар
- ✓ Ерөнхий архитекторын 2021 оны тайлангийн бэлтгэл ажлыг хийсэн.

## **3. БУСАД АЖИЛ:**


### **Захиргаа, хүний нөөц, дотоод ажил:**

#### **Сургалт:**

- ✚ НҮБ-ын дэмжлэгээр Удирдлагын академиас “Төрийн албан хаагчдын ёс зүй, цогц чадамжийн үндэсний жишиг хөтөлбөр” боловсруулах 1 өдрийн сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн оролцсон. Мөн удирдах ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх 2 өдрийн сургалтад газрын дарга оролцсон.



- Угсармал орон сууцны барилгын эрчим хүчний АУДИТ хийх цахим сургалтанд Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөнтөгос хамрагдав.



- Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт багтсан хичээлийн чиглэлээр албан хаагчдаас санал хураасан. Дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулхаар ажиллаж байна.

#### Шүүхийн мэдээлэл:

- “Дархан Ти Ви” ХХК-ын нэхэмжлэлд хариуцагчаар Аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн 2022/01/13-ны өдрийн Дархан-Уул аймгийн анхан шатны шүүх хуралдааныг нэхэмжлэгч талаас өмгөөлөгч авахаар болж 14 хоног хойшлуулсан.

#### Хүний нөөц:

- Аймгийн ТАСЗөвлөлөөс 2021/12/30-ны өдрийн Дугаар 74 албан тоотоор захиалга өгсөн сул орон тоонд 3 нэр дэвшигчийг томилох 71,72,73 дугаар тогтоолын хэрэгжүүлж Суурь судалгаа, газрын мониторингын асуудал хариуцсан мэргэжилтнээр Ү.Оюундарь, Орхон сумын газрын даамлаар Ч.Үүрийнтуяаг, Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал хариуцсан мэргэжилтнээр М.Дарьсүрэн нарыг газрын даргын тушаалаар томилж, холбогдох материалын хамт хүргүүлсэн. Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнээр түр томилогдсон Ч.Анхбаярыг 2022/01/25-ны өдрийн Б/04 тушаалаар чөлөөлж, Дархан сумын газрын даамлаар ажиллаж байсан Ө.Мягмарсүрэн нь Хүүхэд асрах чөлөөний хугацаа нь дуусч ажилдаа эргэж орох хүсэлт ирүүлсний дагуу газрын даргын 2021/01/04-ний өдрийн Б/01 тоот тушаалаар томилж, түр томилогдсон Э.Гүрхандыг чөлөөлсөн.
- 2022 оны ээлжийн амралтын хуваарийг батлуулхаар тушаалын төсөл боловсруулж, албан хаагчдаас санал авсан. Байгууллагын цалингийн санг шинэчлэх тушаалын төслийг боловсруулж байна.
- Мобиком ХХКомпанитай хамтран ажиллаж, хөнгөлөлттэй нөхцөл бүхий Хабрид урамшуулал бүхий **сар бүр 10 gb** дататай багцад хамруулхаар нийт албан хаагчдын судалгааг гаргаж 2022/01/13-ны өдрийн №17 албан тоотын дагуу хүргүүлсэн. Албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж 10 gb дата орж ирсэн.
- Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын бүртгэлийг шинэчлэн оруулсан.
- Аймгийн Засаг дарга, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, ГХБХБГ-ын Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулхаар ГЗБГЗЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Мөнхцэцэгт [munkhtsetseg.qa@gazar.gov.mn](mailto:munkhtsetseg.qa@gazar.gov.mn) хаягт хүргүүлсэн.

#### Маргаан бүхий өргөдөл, гомдол:



✚ Тахько ХК-аас Мотесн ХХК-д газар эзэмших эрх шилжүүлэх тухай өргөдөл ирүүлсний судлан 2022/01/13-ны өдөр Газар эзэмших эрх шилжүүлэхэд шаардлагатай материалыг бүрэн ирүүлэх, газрын төлбөрийн дутууг төлсний дараа эрх шилжүүлхээр болсон хариуг хүргүүллээ.

### Мэдээллийн технологийн чиглэлээр:


70376471 нээлттэй утсаар 11 иргэний асуусан асуултанд хариулсан. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Facebook хуудсанд иргэнээс асуусан 8 асуултанд хариулсан.

Удирдлагын академийн богино хугацааны сургалтын даалгаварыг хийж явуулав. Шинэ үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулан АЗДТГ-аас зохион байгуулсан “АХА” тэмцээнд оролцов.

Байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсний Санхүүгийн мэдээ хэсэгт 2021 оны 12-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Үйл ажиллагааны тайлан хэсэгт 2021 оны 12-р сарын 7 хоног, сарын тайлан, 2021 оны байгууллагын бичмэл тайланг байрлуулав.

2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ	
2021 оны 1-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 2-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 3-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 4-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 6-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 7-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 9-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 10-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 11-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах
2021 оны 12-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Татах


Байгууллагын фэйсбүүк хуудсан дээр шинэ жилийн видео болон зурган мэндчилгээ, Байгууллагын 2021 оны онцлох 5 ажлын постерыг байрлуулав.



Байгууллагын шинэ жилийн видео, болон зурган мэндчилгээ, шинэ жилийн мэндчилгээний карт, 2021 оны онцлох 5 ажлын постерын эхийг бэлтгэж, хэвлэн өгөв.



Сумдын газрын даамлуудтай цахим хурал хийх бэлтгэл ажлыг хангаж, сумдын газрын даамлуудыг цахим хуралд оролцоход туслан заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Мониторингийн мэргэжилтэн, Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын компьютерийг форматлаж, хэрэглээний програмууд, хорт кодын эсрэг програм, драйверуудыг суулгаж өгөв. Сүлжээний гэмтлийг оношлон софтвер-ийг сольж өгөв. Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Дарьсүрэнд өгөх компьютерийг форматлаж, шаардлагатай хэрэглээний програмуудыг суулгаж, хэвлэгчийг таниулж өгөв.



Цахим шилжилтийн сарын аяны онцлох ажлуудын агентлагын хурал дээр танилцуулах тайланг бэлтгэв.



### Нярав:

39 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. 1 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас гологдол байсан тул Цэндээд буцааж өгөв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 23 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгов.

Шаардах хуудсаар 34 төрлийн 733 ширхэг бараа материал олгов.

ААНБ, ТБ-ын газар эзэмших гэрчилгээ, ААНБ, Иргэний газар ашиглах гэрчилгээний 2021 оны зарцуулалтын нэгтгэлийг гаргаж, үлдэгдлийг тоолж, хүлээлгэн өгөхөд бэлтгэв. 2021 оны 12-р сарын бараа материалын зарцуулалтын нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв.

2021 оны 1-3 сар, 9-10 сарын кадастрын үнэт цаас, 1-2 сар, 6-8 сар, 9-10-р сарын газар эзэмших эрхийн гэрчилгээ /Иргэн/-ний зарцуулалтын тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв.

### Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

ГХБХБГ-т 2022 оны 1 сарын 2-ний өдрөөс 1 сарын 25-ны өдрийн хооронд Абле программд нийт 79 албан бичиг /хариутай 53/, 17 өргөдөл /хариутай 16/ ирсэнээс 26 албан бичиг, 3 өргөдөл шийдвэрлэн, 27 албан бичиг, 13 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

*Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:*

**График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл**



Мөн Egazar.gov.mn системээр 289 цахим өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ